



ХЭНТИЙ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 08 сарын 20 өдөр

Дугаар 5/21

Дэлгэрхаан сум

Г.Одонцацралыг үндсэн ажилтнаар томилох тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 48 дугаар зүйлийн 48.1, 49 дүгээр зүйл, 50 дугаар зүйлийн 50.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5 дахь заалт, Засгийн Газрын 2018 оны 382, 2019 оны 06, 2023 оны 240, 2024 оны 84, 238 дугаар тогтоол, Хөдөлмөрийн дотоод журмын 3 дугаар зүйлийн 3.6 дах зүйл, 2025 оны 08 дугаар сарын 18-ны бичгээр гаргасан хүсэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ганзоригийн Одонцацралыг бага ангийн багшийн албан тушаалд 2025 оны 08 дугаар сарын 20-ний өдрөөс томилон ажиллуулсугай.

2. Г.Одонцацралын үндсэн цалинг ТҮБД-3 дугаар шатлал 1484000 (Нэг сая дөрвөн зуун наян дөрвөн мянган) төгрөгөөр, хоолны нөхөн олговор, холбогдох бусад нэмэгдлийг зохих журмын дагуу тооцож олгохыг нягтлан бодогч (Д.Энхсаруул)-д зөвшөөрсүгэй.

3. Г.Одонцацралыг мэргэжил, арга зүйгээр ханган, албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүрэг, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааварчилгааг танилцуулан, хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллуулахыг сургалтын менежер (Б.Ариунчимэг), эд хөрөнгийг данс бүртгэлээр хүлээлгэн өгөхийг нярав (Б.Тогтохжаргал) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын багийн ахлагч (Ж.Энхцэцэг)-т даалгасугай.

ЗАХИРАЛ



Ш.ЦЭРЭНДУЛАМ